



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/02/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 99019800

Цахим хаяг: Narantuuld@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
БТСГ	Биеийн тамир спортын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН
ЗАХИРАГЧ Ж.ДАМДИНБАЗАР ТАНАА

2023.03.24 № 02/МЧ
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Булган сумын татварын орлогыг 1,021.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр батлагдаж гүйцэтгэлээр 935.4 сая орлогыг бүрдүүлэн нийт орлогыг 86.4 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар тасалсан гол шалтгаан нь үйл ажиллагааны орлого 0.9, шууд бус орлого 81.6, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 0.2, бууны албан татвар 1.6, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 88.5, түгээмэл ашигт малтмал ашигласны төлбөр 1.2, хог хаягдлын хураамж 9.2, газрын төлбөр 24.1, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 1.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,615.0 сая төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалд төлөх шимтгэл 57.2, байр ашиглахтай холбоотой зардал 27.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 3.4, урсгал шилжүүлэг 40.5, эргэж төлөгдөх зээл 4.2 сая төгрөгөөр буюу батлагдсан төсвийг 132.6 сая төгрөгөөр хэмнэгдэж, хөрөнгийн зардлыг 34.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Өмнөх онуудад төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн тогтмол зардлаас бусад үзүүлэлтүүд системийн дээд байгууллагын тайланд нэгтгэгдэх бодлогын өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд орсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 04 тоот тогтоолоор Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 6 бодлогын хүрээнд 136 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 86.6 хувийн биелэлттэй гэж үнэлэгджээ.

Мөн ИТХ-ын 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 10 тоот тогтоолоор сумын түүхт 90, 91 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх өдөр, хийх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах талаар Засаг даргад үүрэг болгосон байна.

ЗДТГ-аас 2021 онд сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн 7 албан тушаалтанд 33.4 сая төгрөгийн тэтгэмжийг олгожээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,205,593.8	710,534.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	299,243.8	101,794.6
33	АВЛАГА	537,184.3	556,051.8
34	УРЬДЧИЛГАА	13,000.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	356,165.8	52,688.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,464,288.1	6,109,463.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,464,288.1	6,109,463.8
39200	Биет хөрөнгө	13,042,006.0	5,867,300.5
39300	Биет бус хөрөнгө	422,282.1	242,163.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,669,881.9	6,819,998.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,280.5	17,821.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,280.5	17,821.2
51	Засгийн газрын хувь оролцоо	14,639,601.4	6,802,177.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,669,881.9	6,819,998.4

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,560,721.7	3,617,523.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	294,313.4	860,711.2
110	Орлогын албан татвар	179,891.1	726,430.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	179,891.1	726,430.4
113	Хөрөнгийн албан татвар	72,459.4	83,368.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	41,962.9	50,911.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,405,940.4	1,015,973.8
120	Нийтлэг татварын бус орлого	2,405,940.4	1,015,973.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,860,467.9	1,740,838.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,085,139.5	3,246,942.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,085,139.5	3,246,942.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,528,321.1	3,206,702.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,958,368.9	669,146.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	535,352.4	87,400.7

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,466.8	303,559.3
2104	Хангамж, бараа материалын зардал	611,833.3	1,297,970.0
2105	Нормативт зардал	151,376.9	16,935.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,760.1	6,546.3
2107	Томилолт, зочны зардал	8,678.4	11,967.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,323.0	45,352.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	878,161.3	767,823.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,556,818.4	40,240.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,475,582.2	370,581.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	73.6	8,207,421.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,475,508.6	(7,836,839.9)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	7,606,879.6	2,934,117.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	294,313.4	860,711.2
110	Орлогын албан татвар	179,891.1	726,430.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	179,891.1	726,430.4
113	Хөрөнгийн албан татвар	72,459.4	83,368.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	41,962.9	50,911.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	31,519.2	29,987.2
1181	Газрын төлбөр	1,188.2	11,377.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	9,255.5	9,546.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	422,688.8	319,498.8
120	Нийтлэг татварын бус орлого	422,688.8	319,498.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,889,877.4	1,753,907.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,859,247.5	1,872,780.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,859,247.5	1,872,780.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,286,537.3	1,712,912.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,979,077.1	708,759.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	546,972.9	102,443.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	310,362.2	313,706.0
2104	Хангамж, бараа материалын зардал	85,361.0	82,720.3
2105	Нормативт зардал	118,389.8	768.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,264.9	6,713.3
2107	Томилолт, зочны зардал	9,135.1	16,207.2

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,990.0	51,988.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	158,984.2	429,606.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,572,710.3	159,867.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	747,632.1	1,061,337.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	620,728.1	1,001,686.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	620,728.1	1,001,686.2
2200	Дотоод эх үүсвэрээр	620,728.1	1,001,686.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(620,728.1)	(1,001,686.2)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(59,200.0)	(257,100.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	59,200.0	257,100.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	67,704.0	(197,449.2)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	231,539.7	299,243.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	299,243.8	101,794.6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,165,913.6	13,165,913.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,522.9	1,522.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,167,436.5	13,167,436.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(3,343.7)	(3,343.7)
9	Тайлант үеийн үр дүн	1,475,508.6	1,475,508.6
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,639,601.4	14,639,601.4
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	14,639,601.4	14,639,601.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,077,211.4)	(1,077,211.4)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,562,390.0	13,562,390.0
19	Тайлант үеийн үр дүн	(7,836,839.9)	(7,836,839.9)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,802,177.2	6,802,177.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,713,456.2	2,614,968.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,484,646.6	1,356,182.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,284,339.6	1,196,315.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,133.7	663,443.5
210101	Үндсэн цалин	483,898.4	462,915.9

210102	Нэмэгдэл	113,535.1	95,573.1
210104	Урамшуулал	36,136.6	51,263.3
210105	Гэрээт ажлын хөлс	84,563.6	53,691.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,672.2	88,185.4
210201	Тэтгэврийн даатгал	61,899.7	60,378.3
210202	Тэтгэмжийн даатгал	6,414.4	6,299.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,113.1	5,959.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,492.3	1,413.6
210205	Эрүүл мэндийн даатгал	14,752.7	14,134.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	337,569.1	310,706.0
210301	Гэрэл, цахилгаан	39,103.8	49,365.2
210302	Түлш, халаалт	293,734.4	258,560.9
210303	Цэвэр, бохир ус	4,730.9	2,779.9
2104	Хангамж, бараа материалын зардал	30,273.3	30,056.6
210401	Бичиг хэрэг	2,542.2	2,542.2
210402	Тээвэр, шатахуун	23,324.0	23,324.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,157.1	3,940.4
2105	Нормативт зардал	768.3	768.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	768.3	768.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,164.9	6,713.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	167.0	167.0
210604	Урсгал засвар	6,997.9	6,546.3
2107	Томилот, зочны зардал	12,018.3	11,967.7
210702	Дотоод албан томилот	12,018.3	11,967.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,833.9	45,577.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,008.9	43,933.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420.0	420.0
210803	Даатгалын үйлчилгээ	390.0	343.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235.0	99.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	90.0	90.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	525.0	525.0
210807	Газрын төлбөр	165.0	165.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,905.9	38,897.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,490.4	36,481.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,307.0	159,867.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	159,900.0	119,460.3
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	159,900.0	119,460.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,407.0	40,407.0

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,398.1	33,398.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,866.9	4,866.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,142.0	2,142.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	967,548.9	1,001,686.2
220001	Барилга байгууламж	158,402.4	153,685.2
221001	Их засвар	630,146.5	614,105.9
222001	Тоног төхөөрөмж	124,000.0	184,545.5
223001	Бусад хөрөнгө	55,000.0	49,349.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	261,260.7	257,100.0
230001	Эргэж төлөгдөх зээл	261,260.7	257,100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,713,456.2	2,468,343.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,450,795.5	2,347,378.3
320001	Орон нутгийн төсвөөс	1,379,649.0	1,276,231.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,071,146.5	1,071,146.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	262,660.7	120,965.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,400.0	0.3
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000.0	120,965.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	201,260.7	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	201,260.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	54,636.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
610001	Төсвийн байгууллага	3	3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	39
620001	Удирдах ажилтан	11	11
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15
620003	Үйлчлэх ажилтан	11	11
620004	Гэрээт ажилтан	2	2
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39	39
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	12	12
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	13
650010	Гэрээт ажилтан	5	5
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9	9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	241,918.2	401,279.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	230,802.7	401,279.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,520.7	394,299.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,068.9	-
210401	Бичиг хэрэг	2,068.9	-

2105	Нормативт зардал	11,784.2	-
210502	Хоол, хүнс	9,973.9	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,810.3	-
2107	Томилолт, зочны зардал	-	3,589.5
210702	Дотоод албан томилолт	-	3,589.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,729.4	390,709.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	390,709.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,282.0	6,980.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,282.0	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	71,328.9	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,953.1	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,386.7	6,980.6
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	326.7	-
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	17,060.0	-
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,980.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,115.5	-
2200	Дотоод эх үүсвэрээр	11,115.5	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,115.5	-
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	241,918.2	401,279.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	241,918.2	401,279.6
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,240.0	358,176.7
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,117.5	11,400.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	125,184.8	31,702.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,376.0	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон дараах зорилтыг тавин ажилласан байна.Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих
- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг

- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн нэмэлт өөрчлөлтүүд орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах **шаардлагагүй** гэж үзлээ.

Булган сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,849.9 сая төгрөгөөр буюу 50 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	299.2	101.8	197.4	0.3
Авлага	537.2	556.0	(18.8)	1.0
Урьдчилгаа	13.0	-	13.0	-
Бараа материал	356.1	52.7	303.4	0.1
Үндсэн хөрөнгө	13,464.3	6,109.5	7,354.8	0.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14,669.8	6,820.0	7,849.8	0.5
Богино хугацаат өр төлбөр	30.3	17.8	12.5	0.6
Цэвэр хөрөнгө, өмч	14,639.6	6,802.2	7,837.4	0.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,669.9	6,820.0	7,849.9	0.5

Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн данснууд байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 40 хувиар буурсан гол шалтгаан нь орон нутгийн ЭМТөв, ЕБСургууль, СӨБ, Соёлын байгууллагууд нь улсын төсвөөс санхүүжилт авч тайлан балансаа харьяаны салбарт нэгтгэдэг болсонтой холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 299.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 101.8 сая төгрөгөөс 100.3 сая төгрөг нь Төрийн сангийн дансанд, 1.5 сая төгрөг нь арилжааны банкинд байршиж, 197.4 сая төгрөгөөр буюу 65.9 хувиар буурсан нь тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс зээл олгосонтой холбоотойгоор буурсан байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 556.0 сая төгрөг болж, өмнөх оноос 18.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	3.3	0.1	(3.3)
Байгууллагаас авах авлага	76.0	65.0	(11.0)
Хувь хүмүүсээс авах авлага	113.7	0.2	(113.6)
Зээлийн хүүгийн авлага	338.9	487.6	148.7
Тусгай зориулалтын сан	5.2	3.2	(2.0)
Дүн	537.1	556.0	18.9

Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өссөн гол шалтгаан Хоршоо хөгжүүлэх сангаас 255.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгосон, 65.0 сая төгрөгийн авлага нь ОНХС-аас хийгдсэн ажлууд бүрэн хийгдээгүйтэй холбоотой, тусгай шилжүүлгийн байгууллагатай холбоотой 6.0 сая төгрөгийн авлагыг балансаас балансад шилжүүлсэн байна.

3.4.3 Урьдчилгаа

Тайлант оны эхэнд 13.0 сая төгрөг байсан бол эцэст урьдчилгаа дансны үлдэгдэлгүй байна.
Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	13.0		(13.0)
Дүн	13.0	-	(13.0)

Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой авлага нь Минжит Булган цогцолбор сургуультай холбоотой өмнөх онд үүссэн авлага бүрэн барагдсан байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 52.7 сая төгрөг болж 303.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материал дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Түүхий эд материал	8.7	-	8.7	-
Тусгай зориулалттай материал	6.2		6.2	-
Эм боох материал	2.5		2.5	-
Хангамжийн материал	347.4	52.7	294.7	15.2
Бичиг хэргийн материал	29.6	1.6	28.0	5.4
Аж ахуйн материал	94.4	3.2	91.2	3.4
Түлш шатах тослох материал	100.1	21.6	78.5	21.6
Хүнсний материал	29.1		29.1	-
Бусад хангамжийн материал	77.9	10.0	67.9	12.8
Мал амьтад	16.3	16.3	-	100
Нийт бараа материал	356.1	52.7	303.4	14.8

Тайлант хугацаанд 132.3 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 116.1 сая төгрөгийн материалыг зарцуулж, 319.7 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагуудын балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 17,669.9 сая төгрөг байсан тайлант онд ойн хандив, ОНХС-ийн хөрөнгөөр 928.1 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 9,857.7 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж оны эцэст 8,740.3 сая төгрөг болж 8,929.6 сая төгрөгөөр буурсан байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 30.3 сая, эцсийн үлдэгдэл 17.8 сая төгрөг болж 12.5 сая төгрөгөөр буурч үүний 3.8 сая төгрөг нь сумын ЗДТГ-ын ХХОАТ-ын өр, Минжит Булган ОНӨААТҮГазар нь 3.9 сая төгрөгийн шимтгэлийн өр, аймгийн ЗДТГ-ын 10.0 сая төгрөгийн өглөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 14,639.6 сая төгрөг байснаас оны эцэст 6,802.2 сая төгрөг болж 7,837.4 сая төгрөгөөр буурсан нь нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтөөр улсын төсвийн байгууллагын хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,431.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3,431.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 04 тоот тогтоолоор 3,049.9 сая төгрөгөөр анх баталж 2022 онд 1 удаа тодотгон нэмэлт өөрчлөлт оруулан, сумын ИТХ-аар 2022 оны 06 дугаар сарын 14-ний 02 тоот тогтоолоор нийт 2,713.4 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,379.6, ОНХС-аас 1,071.1 санхүүжих, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.4, туслах үйл ажиллагааны орлогоос 60.0, өмнөх оны үлдэгдлээс 201.3 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр батлагджээ.

<i>Хүснэгт 5. Нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>		<i>/сая төгрөгөөр/</i>	
Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Орон нутгийн төсвөөс санхүүжих	2450.7	2347.3	
Орон нутгийн төсвөөс	1379.6	1276.2	
Орон нутгийн хөгжлийн сан	1071.1	1071.1	
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	262.7	120.9	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	1.4	0	
Туслах үйл ажиллагааны орлогоос	60	120.9	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	201.3		
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	2713.4	2468.2	

Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр орон нутгийн төсөв, татварын болон татварын бус орлого 1,276.2, ОНХС-ийн санхүүжилт 1,071.1, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 121.0 сая төгрөг нийт 2,468.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,614.9 сая төгрөгийг зарцуулж 20.6 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлжээ.

Туслах үйл ажиллагааны орлого буюу Минжит Булган Спорт ордон 10.4, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 92.7, хүүгийн орлого 10.7, алданги 0.6, малжуулах төслөөс 6.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, үндсэн үйл ажиллагааны орлогоос оруулах 1.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлээгүй тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,615.0 сая төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалд төлөх шимтгэл 57.2, байр ашиглахтай холбоотой зардал 27.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 3.4, урсгал шилжүүлэг 40.5, эргэж төлөгдөх зээл 4.2 сая төгрөгөөр буюу

батлагдсан төсвийг 132.6 сая төгрөгөөр хэмнэгдэж, хөрөнгийн зардлыг 34.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Орлогын ангилал	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	1,021.7	935.5	86.2
Нийт орлого ба тусламжийн дүн	930.3	860.8	69.5
Татварын орлого	930.3	860.8	45.0
Орлогын албан татвар	641.6	664.7	(23.1)
Хувь хүний орлогын албан татвар	641.6	664.7	(23.10)
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	534.8	640.4	(105.6)
Үйл ажиллагааны орлого	11.0	10.1	0.9
Шууд бус орлого	95.8	14.2	81.6
Хөрөнгийн албан татвар	204.8	144.7	60.1
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	15.0	14.8	0.2
Бууны албан татвар	3.8	2.2	1.6
Малын тоо толгойн албан татвар	36.0	66.2	(30.2)
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	150.0	61.5	88.5
Бусад татвар, төлбөр, хураамж	38.6	30.6	8.0
Улсын тэмдэгтийн хураамж	25.5	27.9	(2.4)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	3.1	1.9	1.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10.0	0.8	9.2
Газрын төлбөр	35.4	11.3	24.1
Газрын төлбөр	35.4	11.3	24.1
Байгалийн нөөц ашигласны төлбөр	2.6	3.4	(0.8)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	2.6	3.4	(0.8)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	7.3	6.1	1.2
Татварын бус орлого	91.4	74.7	16.7
Торгуулийн орлого	90.0	74.7	15.3
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1.4	-	1.4

Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Татварын орлогыг 935.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нийт орлогыг 86.2 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар тасарсан байна.

Орлого тасарсан гол шалтгаан нь цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 105.6, малын тоо толгойн албан татвар 30.2, улсын тэмдэгтийн хураамж 2.4, ус рашааны нөөц ашигласны төлбөр 0.8 сая төгрөгөөр тус тус орлого давуулан биелүүлж, үйл ажиллагааны орлого, шууд бус орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого, түгээмэл ашигт малтмал ашигласны төлбөр, хог хаягдлын хураамж, газрын төлбөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого 1.2-88.5 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар байгаль орчны барьцаа 3.7, аймгийн ЗДТГ-аас 10.2, аймгийн ИТХ-аас 0.3, Статистикийн хэлтсээс 2.5, аймгийн Онцгой байдлын газраас 28.2, БТСГ-аас 1.9, сумын түүхт ойн хандивт бэлнээр 343.0, газрын төлбөрт 6.3, дуудлага худалдааны дэнчин 1.7, авлага 3.1, бусад 1.0 сая төгрөг нийт 401.2 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс, малын шүлхий өвчний зардалд 28.3, хагас жилийн мал тооллогын зардалд 2.5, шатахууны зардалд 2.1, газрын төлбөрт 2.3, дэнчингийн буцаалт 0.5, урсгал засварт 3.4, өвс тэжээлийн нөөц бэлтгэхэд 10.3, бусад зардалд 1.9, сумын түүхт ойн арга хэмжээний зардалд 343.0 сая төгрөг нийт 394.2 сая төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 7.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2023 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ний өдрийн 1/49 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,246.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 48.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 75 хувиар буюу 36.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗДТГ-аас сумын ойн арга хэмжээний зардалд 2.8 сая төгрөгийн зардал гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд ИТХ-ын цалингийн зардлаас бусад зардлын таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын ажил гүйлгээг бүрэн мэдээлээгүйг аудитын явцад залруулан, Орон нутгийн хөгжлийн сан, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дараа жилийн төсвийн төсөл, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан баланс, батлагдсан төсвийн мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 0.8 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулан, 170.7 сая төгрөгийн 2 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, зөвлөмжийн хэрэгжилт 72 хувьтай байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая. төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	0.8	1	0.8	-	-	100
Албан шаардлага	2	170.7	2	170.7	-	-	100
Зөвлөмж	13	422.1	11	303.3	2	118.8	72
Нийт дүн	16	593.6	14	474.8	2	118.8	90.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл, Малжуулах төслийн зээлийн авлага, сумын түүхт ойн хандивын зарцуулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээ, хөтөлбөр, шатахууны зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 368.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг бүрэн залрууллаа. Үүнд:

- ТТЗ, ЗДТГ, Минжит Булган ОНӨААТҮГ, сумын 90 жилийн хандивын мөнгийг хувь хүний харилцах дансаар нийт 351.5 сая төгрөгийн орлогыг мөнгөн гүйлгээний, санхүүгийн үр дүнгийн тайланд дутуу бүртгэсэн,
- Өглөг 5.6 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан,
- Авлагыг 2.3 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн,
- Шилэн дансны тухай хуульд заасны дагуу сумын ИТХурал цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого буюу санхүүжилтийн мэдээллийг мэдээлээгүй,
- Тайлант үеийн үр дүнг 9.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 186.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 186.3 сая төгрөгийн 7 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

5.1.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баланс дахь авлагын үлдэгдэл, Хоршоо хөгжүүлэх сангийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн систем дэх үлдэгдэл зөрүүтэй, сангаас зээл олгохдоо барьцаалбар үүсгээгүй, барьцаа хөрөнгийг үнэлсэн жагсаалт үйлдээгүй нь Хошоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 6.10.7-д "барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувь болон барьцаа хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж барьцаалбар үйлдсэн тухай баримтыг хавсаргана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэсэн заалтын хэрэгжилт хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Олгосон зээлүүдэд барьцаалбар үүсгэн улсын бүртгэлд бүртгүүлэх, авлагын үлдэгдлийг санхүүгийн тайланд зөв илэрхийлэх,

5.1.2 Бараа материалын тайлан гаргалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Минжит Булган ОНӨААТҮГ газар тайлант онд худалдан авсан бараа материалын тайлан бүрэн гаргаагүй, жолоочийн тооцоог бодоогүй, ОНХС-аас зарцуулсан эд хариуцагчийн тайлан гаргаагүй, 63.9 сая төгрөгийн шатахууныг худалдан авч зарцуулсан, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, хэчнээн шатахуун олгоод ямар ажил хийж гүйцэтгэсэн, хүлээн авсан талаар анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалын НХМаягт БМ-9-д "бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалган хүлээж авна” , Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана”, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгнө” гэсэн заалтуудыг мөрдөөгүй.

***Өгсөн зөвлөмж:** Эд хариуцагчийн дүрэмд заасны дагуу тайланг тухай бүрд нь гаргах, шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах*

5.1.3 Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ-ын дарга томилолтоор ажиллуулахаар өөрийгөө томилсон, Минжит Булган ОНӨАТҮГ, ИТХ томилолтын мөнгө олгохдоо бүрэн бус анхан шатны баримтаар 3.7 сая төгрөгийг зарцуулсан, сумын түүхт ойн арга хэмжээний орлого, зарцуулалтын тайлан гаргаагүй, сумын малчдаас ойд хандивласан малын тоо, зарцуулаад үлдсэн малыг бүртгэлд тусгаагүй, анхан шатны баримтуудыг бүрдүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" , 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

***Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг гаргахгүй байх, ойн арга хэмжээний тайланг нэгтгэн гаргах, холбогдох баримтуудыг үдэж цэгцлэх,*

5.1.4 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-аас аварга хөтөлбөр, иргэдийн санал санаачилга арга хэмжээгээр тэмцээн уралдаан, цагаан сарын барилдаанд, Минжит Булган цогцолбор сургуулийн зөөлөн эдлэл нийлүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, сангийн хөрөнгөөр худалдан авсан хэчнээн тонн тэжээл ирсэн эсэх нь тодорхойгүй багуудад хуваарилсан тоо хэмээ, хэчнээн өрхүүдэд олгосон зэрэг нотлох анхан шатны баримтгүй, сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг хүлээн авсан тайлангүй, эд хариуцагчийн дансаар дамжуулан ажил гүйлгээ гаргасан бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй нийт 109.6 сая төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" , 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалын НХМаягт МХ-4 "мөнгөний нярав орлого, зарлагын баримтууд, мөнгө олгохыг хүссэн өргөдөл зэргийг үндэслэн баримт тус бүрээр өдөр бүр бэлэн мөнгөний гүйлгээний тайланг 2 хувь үйлдэн, 1 хувийг холбогдох баримтуудын хамт нягтлан бодогчид тушааж, үлдэх хувийг өөртөө үлдээнэ. Нягтлан бодогч бэлэн мөнгөн гүйлгээний тайлангийн хуудсыг нь хосоор ижил дугаарлаж няравт өгөх бөгөөд тэрхүү дугаарын тоо санхүүгийн жилд тасралтгүй мөрдөгдөж байвал зохионо", НХМаягт БМ-9-д "бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалган хүлээж авна” , Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана”, 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгнө” гэсэн заалтын хэрэгжилт хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хариуцагчийн тайланг бүрэн гаргах хэвших, сангийн хөрөнгийн зарцуулалт, анхан шатын баримтыг бүрэн бүрдүүлэх,

5.1.5 Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Газрын төлбөрийн орлогыг сумын ЗДТГ-ын нэмэлт дансаар дамжуулан 6.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг мөрдөөгүй.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн газрын төлбөрийн орлогын дансанд төвлөрүүлэх, орлогыг бүрэн бүрдүүлэн ажиллах

5.1.6 Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ-аас сумын ойн арга хэмжээний зардалд 2.8 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" , Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэсэн заалтыг мөрдөөгүй.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасны дагуу төсвийг үр дүнтэй зарцуулан ажиллах

5.1.7 Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дараа жилийн төсвийн төсөл, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан баланс, батлагдсан төсвийн мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;", 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;",

Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд орлого зөрүүтэй, Сумын 90 жилийн ойн хандивын орлогыг тусгаагүй орхигдуулсан/ ТТЗ, ЗДТГ, Минжит Булган ОНӨТҮГ/	2	351.5			2	351.5	2	351.5
Өглөг зөрүүтэй илэрхийлсэн / ЗДТГ, Минжит Булган ОНӨТҮГ/	2	5.6			2	5.6	1	5.6
Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого буюу санхүүжилтийг мэдээлээгүй /ИТХ/	1	-	1				1	
Авлага зөрүүтэй илэрхийлсэн	1	2.3	1	2.3			1	2.3
Тайлант үеийн болон өмнөх үр дүн зөрүүтэй илэрхийлсэн /ЗДТГ, Минжит Булган ОНӨТҮГ/	2	9.0			2	9.0	2	9.0
Дүн	8	368.4	2	2.3	6	366.1	7	368.4

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс			
	Нийт алдаа		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баланс дахь авлагын үлдэгдэл, Хоршоо хөгжүүлэх сангийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн систем дэх үлдэгдэл зөрүүтэй, сангаас зээл олгохдоо барьцаалбар үүсгээгүй, барьцаа хөрөнгийг үнэлсэн жагсаалт үйлдээгүй	1	-	1	
Тайлант онд худалдан авсан бараа материалын тайланг бүрэн гаргаагүй, жолоочийн тооцоог бодоогүй, ОНХС-аас зарцуулсан шатахууны орлого, зарцуулалтын эд хариуцагчийн тайлан гаргаагүй, шатахуун олгоод ямар ажил хийж гүйцэтгэсэн, хүлээн авсан талаар анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй / ОНХС, Минжит Булган ОНӨАТҮГ/	1	63.9	1	63.9
Томилолтын мөнгө олгохдоо бүрэн бус анхан шатны баримтаар олгосон, ЗДТГ-ын дарга нь томилолтоор ажиллуулахаар өөрийгөө томилдог /ЗДТГ, Минжит Булган ОНӨАТҮГ, ИТХ/, сумын түүхт ойн арга хэмжээний орлого, зарцуулалтын тайлан гаргах анхан шатны баримтыг бүрдүүлээгүй	1	3.7	1	3.7
ОНХС-аас аварга хөтөлбөр, иргэдийн санал санаачилга арга хэмжээгээр тэмцээн уралдаан, цагаан сарын барилдаанд, Минжит Булган цогцолбор сургуулийн зөөлөн эдлэл нийлүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, сангийн хөрөнгөөр худалдан авсан хэчнээн тонн тэжээл ирсэн эсэх нь тодорхойгүй багуудад хуваарилсан тоо хэмээ, хэчнээн өрхүүдэд олгосон зэрэг нотлох анхан шатны баримтгүй, сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг хүлээн авсан тайлан бүрэн бус, эд хариуцагчийн дансаар дамжуулан ажил гүйлгээ гаргасан бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй	1	109.6	1	109.6
Газрын төлбөрийн орлогыг ЗДТГ-ын дансанд төвлөрүүлсэн	1	6.3	1	6.3
Дүн	5	183.5	5	183.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил				
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дараа жилийн төсвийн төсөл, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан баланс, батлагдсан төсвийн мэдээллийг байршуулаагүй	1	-	1	-
Дүн	1	-	1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил				
ЗДТГ-ын санхүүжилтээр сумын ойн арга хэмжээний зардалд зарцуулсан	1	2.8	1	2.8
Дүн	1	2.8	1	2.8
Нийт дүн	2	2.8	2	2.8

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР